

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/59/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: С.Батсуурь
Утас: 70453799, Цахим хаяг: Batsuuris@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Дүгнэлтийн үндэслэл	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	3
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал.....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5.1 Завсрын аудитын талаар	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ЗАВХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Ц.ХАДБААТАР ТАНАА

2023.02.24 № УВА-2023/59/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0200700569

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.00	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,101,700.00</u>	<u>11,150,100.00</u>
35.00	БАРАА МАТЕРИАЛ	10,101,700.00	11,150,100.00
354.00	Хангамжийн материал	10,101,700.00	11,150,100.00
35,410.00	Бичиг хэргийн материал	344,400.00	372,800.00
35,420.00	Аж ахуйн материал	2,119,500.00	2,119,500.00
35,440.00	Түлш, шатах тослох материал	0.00	1,020,000.00
35,470.00	Бусад хангамжийн материал	7,637,800.00	7,637,800.00
2.00	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,706,587.57</u>	<u>3,508,837.45</u>
39.00	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,706,587.57	3,508,837.45
392.00	Биет хөрөнгө	4,706,587.57	3,508,837.45
39,205.00	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,485,000.00	10,485,000.00
39,206.00	Хуримтлагдсан элэгдэл	(9,656,146.01)	(10,097,396.09)
39,207.00	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,246,535.00	10,246,535.00
39,208.00	Хуримтлагдсан элэгдэл	(6,368,801.42)	(7,125,301.46)
3.00	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>14,808,287.57</u>	<u>14,658,937.45</u>
5.00	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>14,808,287.57</u>	<u>14,658,937.45</u>
51.00	Засгийн газрын хувь оролцоо	14,808,287.57	14,658,937.45
511.00	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,286,518.00	5,286,518.00
51,101.00	Өмч: - төрийн	5,286,518.00	5,286,518.00
512.00	Хуримтлагдсан үр дүн	9,478,801.57	9,329,451.45
51,210.00	Өмнөх үеийн үр дүн	9,478,801.57	9,478,801.57
51,220.00	Тайлант үеийн үр дүн	0.00	(149,350.12)
51,230.00	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51,300.00	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	42,968.00	42,968.00
6.00	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>14,808,287.57</u>	<u>14,658,937.45</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	83,552,200.00	86,334,700.00
13.00	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	83,552,200.00	86,334,700.00
1,311.00	Нэмэлт санхүүжилтийн орлого	725,000.00	0.00
131,104.00	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	725,000.00	0.00
1,320.00	Орон нутгийн төсвөөс санхүүжих	82,827,200.00	86,334,700.00
132,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	82,827,200.00	86,334,700.00
2.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	82,092,050.12	86,484,050.12
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	82,092,050.12	86,484,050.12
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,474,042.12	66,754,779.05
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,469,521.00	43,240,332.61
210,101.00	Үндсэн цалин	30,109,521.00	28,699,234.37
210,102.00	Нэмэгдэл	0.00	3,763,069.84
210,104.00	Урамшуулал	9,360,000.00	10,778,028.40
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,771,311.00	5,004,946.32
210,201.00	Тэтгэврийн даатгал	3,547,381.19	3,491,413.37
210,202.00	Тэтгэмжийн даатгал	394,695.21	410,754.13
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	315,756.17	325,243.30
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	46,679.85	70,395.00
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	466,798.58	707,140.52
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	6,906,760.00	9,341,050.00
210,401.00	Бичиг хэрэг	985,260.00	1,123,000.00
210,402.00	Тээвэр, шатахуун	5,921,500.00	8,146,050.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	72,000.00
2,107.00	Томилолт, зочны зардал	720,400.00	900,000.00
210,702.00	Дотоод албан томилолт	720,400.00	900,000.00
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	744,000.00	714,000.00
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	600,000.00	534,000.00
210,802.00	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.00	90,000.00
210,806.00	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	90,000.00
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	2,862,050.12	7,554,450.12
210,901.00	Бараа үйлчилгээний бусад зардал	311,300.00	1,773,600.00
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,308,000.00	4,583,100.00
210,903.00	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,242,750.12	1,197,750.12
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,618,008.00	19,729,271.07
2,132.00	Бусад урсгал шилжүүлэг	14,600,900.00	10,453,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,287,700.00	10,453,000.00

2,134.00	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,017,108.00	9,276,271.07
3.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,460,149.88</u>	<u>(149,350.12)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	<u>89,999.68</u>	
2250001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	89,999.68	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	89,999.68	
5.00	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,370,150.20</u>	<u>(149,350.12)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	83,552,200.00	86,334,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	83,552,200.00	86,334,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	725,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	725,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	82,827,200.00	86,334,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	82,827,200.00	86,334,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	83,552,200.00	86,334,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	83,552,200.00	86,334,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	57,503,792.00	66,655,428.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,469,521.00	43,240,332.61
210101	Үндсэн цалин	30,109,521.00	28,699,234.37
210102	Нэмэгдэл	00.00	3,763,069.84
210104	Урамшуулал	9,360,000.00	10,778,028.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,771,311.00	5,004,946.32
210201	Тэтгэврийн даатгал	3,547,381.19	3,491,413.37
210202	Тэтгэмжийн даатгал	394,695.21	410,754.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	315,756.17	325,243.30
210204	Ажилгүйдлийн даатгал	46,679.85	70,395.00
210205	Эрүүл мэндийн даатгал	466,798.58	707,140.52
2104	Хангамж, бараа материалын зардал	4,466,360.00	9,035,400.00
210401	Бичиг хэрэг	920,860.00	1,187,400.00
210402	Тээвэр, шатахуун	3,420,600.00	7,776,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	124,900.00	72,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	00.00
210602	Тавилга	2,000,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	720,400.00	900,000.00
210702	Дотоод албан томилолт	720,400.00	900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	834,000.00	714,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	672,000.00	534,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.00	90,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,000.00	90,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,242,200.00	7,760,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,934,200.00	3,177,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,308,000.00	4,583,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,048,408.00	19,679,271.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,031,300.00	10,403,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,718,100.00	10,403,000.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,017,108.00	9,276,271.07
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээн ий нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	5,286,518.00	42,968.00	8,381,368.15	0.00	13,710,854.15
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,286,518.00	42,968.00	8,381,368.15	0.00	13,710,854.15
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(272,716.78)	0.00	(272,716.78)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,286,518.00	42,968.00	9,478,801.57	0.00	14,808,287.57
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	5,286,518.00	42,968.00	9,478,801.57	0.00	14,808,287.57
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,286,518.00	42,968.00	9,478,801.57	0.00	14,808,287.57
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(149,350.12)	0.00	(149,350.12)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,286,518.00	42,968.00	9,329,451.45	0.00	14,658,937.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,334,700.00	86,334,700.00		
УРСГАЛ ЗАРДАЛ	86,334,700.00	86,334,700.00		
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	86,334,700.00	77,058,428.93	9,276,271.07	89.3%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,411,700.00	43,240,332.61	4,171,367.39	91.2%
Үндсэн цалин	37,369,300.00	28,699,234.37	8,670,065.63	76.8%
Нэмэгдэл		3,763,069.84	(3,763,069.84)	
Урамшуулал	10,042,400.00	10,778,028.40	(735,628.40)	107.3%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,926,400.00	5,004,946.32	921,453.68	84.5%
Тэтгэврийн даатгал	4,030,000.00	3,491,413.37	538,586.63	86.6%
Тэтгэмжийн даатгал	474,100.00	410,754.13	63,345.87	86.6%
ҮОМШӨ-ний даатгал	379,300.00	325,243.30	54,056.70	85.7%
Ажилгүйдлийн даатгал	94,800.00	70,395.00	24,405.00	74.3%
Эрүүл мэндийн даатгал	948,200.00	707,140.52	241,059.48	74.6%
Хангамж, бараа материалын зардал	9,049,200.00	9,035,400.00	13,800.00	99.8%
Бичиг хэрэг	1,187,500.00	1,187,400.00	100.00	100.0%
Тээвэр, шатахуун	7,776,200.00	7,776,000.00	200.00	100.0%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	85,500.00	72,000.00	13,500.00	84.2%
Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	0	2,000,000.00	0.0%
Тавилга	2,000,000.00	0	2,000,000.00	0.0%
Томилолт, зочны зардал	1,060,200.00	900,000.00	160,200.00	84.9%
Дотоод албан томилолт	1,060,200.00	900,000.00	160,200.00	84.9%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,121,500.00	714,000.00	407,500.00	63.7%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	875,600.00	534,000.00	341,600.00	61.0%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	90,000.00		100.0%
Мэдээлэл технологийн үйлчилгээ	155,900.00	90,000.00	65,900.00	57.7%
Бараа үйлчилгээний бусад зардал	8,519,100.00	7,760,750.00	758,350.00	91.1%
Бараа үйлчилгээний бусад зардал	3,936,000.00	3,177,650.00	758,350.00	80.7%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,583,100.00	4,583,100.00		100.0%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,246,600.00	10,403,000.00	843,600.00	92.5%
Бусад урсгал шилжүүлэг	11,246,600.00	10,403,000.00	843,600.00	92.5%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,246,600.00	10,403,000.00	843,600.00	92.5%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	86,334,700.00	86,334,700.00		100.0%
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	86,334,700.00	86,334,700.00		100.0%
Орон нутгийн төсвөөс	86,334,700.00	86,334,700.00		100.0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0		
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0%
Төсвийн байгууллага	1	1		100.0%
АЖИЛЛАГСАДЫН ТОО	3	3		100.0%
Удирдах ажилтан	1	1		100.0%
Гүйцэтгэх ажилтан	2	2		100.0%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нутгийн өөрөө удирдах байгууллагын үр нөлөөг дээшлүүлж, Монгол Улсын Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх үйлсэд иргэдийн оролцоо хүчин чармайлтыг тал бүрээр өрнүүлэн, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэхэд сумын Засаг захиргаа, төрийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэх зорилго бүхий байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Завхан сумын ИТХ нь байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, төсвийн тухай хууль, бусад хууль, тогтоомжуудыг мөрдөн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ. Тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Завхан сумын ИТХ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон гэж үзэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Завхан сумын ИТХ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,197.7 мянган төгрөгөөр буюу 25.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	10,101.7	11,150.1	1,048.4
Үндсэн хөрөнгө	4,706.5	3,508.8	(1,197.7)
Нийт хөрөнгө	14,808.2	14,658.9	(149.3)
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	14,808.2	14,658.9	(149.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	14,808.2	14,658.9	(149.3)

Тайлант оны эцэст авлагын үлдэгдэлгүй байна.

Бараа материал дансны үлдэгдэл 11,150.1 мянган төгрөг болж 1,048.4 төгрөгөөр нэмэгдсэн нь хангамжийн материал нэмэгсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,508.8 мянган төгрөг болж 1,197.7 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 86,334.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 86,334.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 86,334.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 86,334.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 77,058.4 мянган төгрөг буюу 89.3 хувьтай зарцуулж, 9,276.2 мянган төгрөгийг төвлөрүүлэн ажиллажээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	86,334,700.00	77,058,428.93	9,276,271.07	89.3%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Завхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Батсуурь гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Завхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 820.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 86,484.0 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 864.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 691.5 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Завхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа байршуулсан 148 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 1, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Завхан сумын ИТХ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчил гараагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Завхан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТЦУУРЬ/
АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР /С.БАТЦУУРЬ/

2023 оны 02 дугаар сарын 24-ны өдөр